

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/43/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

---

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт .....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НХМ	Нэг хэвийн маягт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tiv@audit.gov.mn

2022.02.25 № 01/99  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА А.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАВГАЛ  
19020340

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,048,808.44</b>	<b>41,661,668.44</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	37,048,808.44	41,661,668.44
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	92,066.44	92,066.44
35110	Тусгай зориулалттай материал	92,066.44	92,066.44
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	29,156,742.00	33,769,602.00
35410	Бичиг хэргийн материал	1,552,664.00	1,915,664.00
35420	Аж ахуйн материал	9,168,788.00	8,539,288.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,143,000.00	160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,062,100.00	5,015,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,230,190.00	18,139,650.00
35600	Мал амьтад	7,800,000.00	7,800,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>875,151,139.77</b>	<b>1,339,948,545.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	875,151,139.77	1,339,948,545.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	665,068,639.77	1,105,119,545.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	688,588,968.00	1,184,793,143.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-175,562,775.51	-213,455,636.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,434,866.00	141,434,866.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,559,921.26	-105,166,797.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,214,600.00	166,611,533.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,301,016.93	-90,182,747.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,019,946.00	69,989,409.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,766,026.53	-48,904,224.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	210,082,500.00	234,829,000.00
39301	Програм хангамж	1,647,500.00	1,647,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-953,000.00	-1,206,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	209,388,000.00	234,388,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>912,199,948.21</b>	<b>1,381,610,214.33</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>912,199,948.21</b>	<b>1,381,610,214.33</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	912,199,948.21	1,381,610,214.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	668,904,654.51	668,904,654.51
51101	Өмч: - төрийн	668,904,654.51	668,904,654.51
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	112,792,433.99	582,202,700.11
51210	Өмнөх үеийн үр дүн	112,792,433.99	112,792,433.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	469,410,266.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,502,859.71	130,502,859.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>912,199,948.21</b>	<b>1,381,610,214.33</b>

**Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>392,205,478.90</b>	<b>895,052,890.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>57,334,522.00</b>	<b>550,175,475.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	57,334,522.00	550,175,475.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,334,522.00	550,175,475.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,334,522.00	550,175,475.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>334,870,956.90</b>	<b>344,877,415.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,352,656.90	13,819,915.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,352,656.90	13,819,915.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	323,518,300.00	331,057,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,518,300.00	331,057,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>406,318,611.28</b>	<b>424,138,457.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>406,318,611.28</b>	<b>424,138,457.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	395,388,419.73	418,608,322.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	220,864,255.02	220,886,219.94
210101	Үндсэн цалин	129,191,990.83	138,864,819.94
210102	Нэмэгдэл	44,347,309.84	34,696,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,324,954.35	47,325,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,539,750.33	29,821,767.00
210201	Тэтгэврийн даатгал	20,867,313.64	20,986,267.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,053,868.01	2,208,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,853,599.12	1,767,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	423,012.65	441,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,341,956.91	4,417,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,012,139.00	33,350,116.00
210301	Гэрэл, цахилгаан	10,175,459.00	10,787,776.00
210302	Түлш, халаалт	21,161,480.00	21,875,640.00
210303	Цэвэр, бохир ус	675,200.00	686,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,673,273.28	25,078,229.63
210401	Бичиг хэрэг	2,888,830.00	2,521,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,595,800.00	13,833,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	749,300.00	1,099,229.63
210404	Ном, хэвлэл	73,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	580,000.00
210408	Бараа материал акталсны зардал	4,365,943.28	7,044,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	436,300.00	941,500.00
210604	Урсгал засвар	436,300.00	941,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,400,000.00	2,541,500.00
210702	Дотоод албан томилолт	2,400,000.00	2,541,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,142,691.00	3,677,288.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	10,773,841.00	2,377,481.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,850.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	323,500.00	579,104.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	303,500.00	119,928.00

**Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,320,011.10	102,311,702.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,562,000.00	23,246,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	78,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,758,011.10	78,987,602.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,930,191.55	5,530,134.43
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,812,900.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,109,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	703,500.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,</b>	117,291.55	5,530,134.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,291.55	5,530,134.43
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-14,113,132.38</b>	<b>470,914,432.72</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	1,504,166.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,504,166.60
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-1,504,166.60
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-14,113,132.38</b>	<b>469,410,266.12</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	668,904,654.51	130,675,055.59	126,733,370.49	00.00	926,313,080.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	172,195.88	00.00	172,195.88
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>668,904,654.51</b>	<b>130,675,055.59</b>	<b>126,905,566.37</b>	<b>00.00</b>	926,485,276.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,113,132.38	00.00	-14,113,132.38
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>668,904,654.51</b>	<b>130,502,859.71</b>	<b>112,792,433.99</b>	<b>00.00</b>	912,199,948.21
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>668,904,654.51</b>	<b>130,502,859.71</b>	<b>112,792,433.99</b>	<b>00.00</b>	912,199,948.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>668,904,654.51</b>	<b>130,502,859.71</b>	<b>112,792,433.99</b>	<b>00.00</b>	912,199,948.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	469,410,266.12	00.00	469,410,266.12
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>668,904,654.51</b>	<b>130,502,859.71</b>	<b>582,202,700.11</b>	<b>00.00</b>	1,381,610,214.33

**Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>334,870,956.90</b>	<b>344,877,415.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>334,870,956.90</b>	<b>344,877,415.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,352,656.90	13,819,915.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	11,352,656.90	13,819,915.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	323,518,300.00	331,057,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	323,518,300.00	331,057,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>334,870,956.90</b>	<b>344,397,415.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>334,870,956.90</b>	<b>344,397,415.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>323,646,765.35</b>	<b>338,867,280.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	220,864,255.02	220,886,219.94
210101	Үндсэн цалин	129,191,990.83	138,864,819.94
210102	Нэмэгдэл	44,347,309.84	34,696,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,324,954.35	47,325,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,539,750.33	29,819,700.00
210201	Тэтгэврийн даатгал	20,867,313.64	20,984,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,053,868.01	2,208,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,853,599.12	1,767,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	423,012.65	441,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,341,956.91	4,417,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,063,239.00	35,254,916.00
210301	Гэрэл, цахилгаан	10,408,193.00	10,787,776.00
210302	Түлш, халаалт	22,929,846.00	23,828,540.00
210303	Цэвэр, бохир ус	725,200.00	638,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,170,420.00	12,898,629.63
210401	Бичиг хэрэг	3,260,820.00	2,701,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,058,300.00	6,576,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	851,300.00	1,402,229.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,218,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	1,101,500.00
210604	Урсгал засвар	00.00	1,101,500.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	2,400,000.00	2,541,500.00
210702	Дотоод албан томилолт	2,400,000.00	2,541,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	14,967,621.00	6,666,715.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	13,624,621.00	5,366,908.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	286,000.00	286,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	227,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	356,807.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,641,480.00	29,698,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,641,480.00	29,620,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	78,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,224,191.55</b>	<b>5,530,134.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,106,900.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,109,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	997,500.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох</b>	117,291.55	5,530,134.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,291.55	5,530,134.43
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>480,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>480,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>480,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	480,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	480,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-480,000.00</b>

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	331,057,500.00	327,456,372.57
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	331,057,500.00	327,456,372.57
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	331,057,500.00	327,456,372.57
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	220,886,300.00	220,886,219.94
210101	Үндсэн цалин	138,864,900.00	138,864,819.94
210102	Нэмэгдэл	34,696,400.00	34,696,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,325,000.00	47,325,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,819,700.00	29,819,700.00
210201	Тэтгэврийн даатгал	20,984,200.00	20,984,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,208,900.00	2,208,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,767,100.00	1,767,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	441,800.00	441,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,417,700.00	4,417,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,570,900.00	35,254,916.00
210301	Гэрэл, цахилгаан	10,106,100.00	10,787,776.00
210302	Түлш, халаалт	24,826,200.00	23,828,540.00
210303	Цэвэр, бохир ус	638,600.00	638,600.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,981,900.00	12,980,129.63
210401	Бичиг хэрэг	2,701,300.00	2,701,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,576,600.00	6,576,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,404,000.00	1,402,229.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	2,300,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,779,600.00	2,541,500.00
210702	Дотоод албан томилолт	5,779,600.00	2,541,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,343,000.00	6,299,807.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	286,000.00	286,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	227,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	356,807.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,176,100.00	18,174,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,176,100.00	18,174,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	331,057,500.00	331,057,500.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	331,057,500.00	331,057,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	331,057,500.00	331,057,500.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24.00	23.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,352,656.90</b>	<b>13,819,915.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,352,656.90</b>	<b>13,819,915.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,352,656.90</b>	11,890,908.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	5,354,621.00	366,908.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	5,354,621.00	366,908.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,891,480.00	11,524,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,891,480.00	11,446,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	78,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>106,555.90</b>	1,929,007.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	106,555.90	1,929,007.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,352,656.90</b>	<b>13,819,915.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>11,352,656.90</b>	<b>13,819,915.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,352,656.90	13,819,915.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд батлагдсан ба 2013 оноос хойш шинэчлэгдэн өөрчлөгдсөн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын өөрчлөлт хийгдээгүй байна.

Архуст сумын ЗДТГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ны А/04 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажиллах журмын дагуу 4 бүлэг 24 асуумжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, салбар нэгжид удирдлагын бодлого, шийдвэр хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгээр зөвлөн туслах хяналт хийдэг байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь тус байгууллагад 2021 оны 01 дүгээр сард тусгай сангуудын үйл ажиллагаанд, 2021 оны 10 дугаар сард 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архуст сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Архуст сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Архуст сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 334,870.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,023.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,018.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг Архуст сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дүнгээс тооцсонтой холбоотойгоор гүйцэтгэлийн үе шатанд Архуст сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 344,397.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,165.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 4,132.7 мянган төгрөгөөр тус тус тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 142.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал 114.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨТХ, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдлөг болгон Санхүүгийн тайланг “Payroll”, “Acolous” программыг ашиглан тайлагнасан байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 331,057.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,819.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 344,877.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 480.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй орлогоор 544,809.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 28,718.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

**Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 50,733.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй орлогоор 5,366.3 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, 44,442.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 7,044.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан ба харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Санхүү байдлын тайлангаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 41,661.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,339,948.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	37,048.8	41,661.7	4,612.9
Үндсэн хөрөнгө	875,151.1	1,339,948.5	464,797.4
Нийт хөрөнгө	912,199.9	1,381,610.2	469,410.3
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	912,199.9	1,381,610.2	469,410.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	912,199.9	1,381,610.2	469,410.3

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 41,661.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 4,612.9 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын нөөц бүрдүүлэлтээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,339,948.5 мянган төгрөг болж 464,797.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 520,289.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,381,610.2 мянган төгрөг болж 469,410.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 354,982.8 мянган төгрөгөөр төлөвлөж, бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 23,925.3 мянган төгрөгөөр бууруулан 331,057.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс, шимтгэлийн болон тогтмол зардал хасагдсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 331,057.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 327,456.4 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3,601.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 327,456.4 мянган төгрөг буюу 98,9 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд усны санхүүжилтэд 4,989.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 6,000.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн санхүүжилтэд 300.0 мянган төгрөг, хагас жилийн малын тооны санхүүжилтэд 366.9 мянган төгрөг, ариутгал, био техникийн болон тендерийн санхүүжилтэд 2,164.0 мянган төгрөг нийт 13,819.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас Ковид-19 бэлтгэл бэлэн байдлын зардалд 4,950.0 мянган төгрөг, түргэвчилсэн оношлуур, халдвар хамгааллын зардалд 2,256.0 мянган төгрөг, худаг уст цэгийн зардалд 3,440.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, хагас жилийн малын тооллогын зардалд 366.9 мянган төгрөг, био техникийн ажлын зардалд 500.0 мянган төгрөг, сургалтын зардалд 78.0 мянган төгрөг, нийт 11,890.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,929.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны батлагдсан зардлаас Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд буюу түргэвчилсэн оношлуурын үнэнд 991.0 мянган төгрөг, багаж, тоног төхөөрөмж авахад 5,913.9 мянган төгрөг, бэлэн байдлын нөөц бүрдүүлэхэд 3,500.0 мянган төгрөг, хөдөлгөөн хяналт хийхэд 1,210.0 мянган төгрөг нийт 11,614.9 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөг ирүүлснийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, мөн аймгийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар 5,000.0 мянган төгрөг ирүүлснийг Ковид-19 бэлтгэл бэлэн байдлын зардалд 4,950.0 мянган төгрөг урьд оны үлдэгдлээс 756.0 мянган төгрөгийг түргэвчилсэн оношлуурын үнэнд зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Архуст сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 07 дугаар тогтоолын дагуу тайлант онд үндсэн хөрөнгийн данснаас 28,718.6 мянган төгрөгийн, бараа материалын данснаас 7,044.2 мянган төгрөгийг акталж, данснаас хассан. Уг тогтоолоор ЗДТГ-ын ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон хөрөнгийг нягтлан шалгаж дахин үнэлгээ тогтоох боломжтой эсэхэд хяналт хийж, тайланг 2022 оны 1 дүгээр улиралд Хурлын хуралдаанд хэлэлцүүлэх үүрэг болгосон. Аудитад ирсэн тайлбарыг үндэслэн уг тогтоолоор өмнөх онуудын өвсний 4,727.0 мянган төгрөгийн үлдэгдлийг хассан болон бусад хөрөнгийг нягтлан шалгаж ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлэх талаар албан шаардлага өгсөн.

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 480.0 мянган төгрөгийн, аймгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр 544,809.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, сумын ИТХ-ын тогтоолоор 28,718.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 35, огт байршуулаагүй 4, хугацаандаа байршуулсан 110 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, өмнөх оны хэмнэлт, давсан урамшуулал, хандив тусламж, түүний зарцуулалт, худалдан авах ажиллагааны тайлан зэргийг байршуулж, мэдээлээгүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн №06/46 тоот албан бичгээр ирүүлсэн

боловч тайлант оны мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг огт байршуулаагүй тул албан шаардлага бичив.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Аудитаар бичигдсэн албан шаардлагын хэрэгжилт буюу данснаас хасагдсан хөрөнгийн шийдвэрлэлт, ИТХ-ын хуралдааны шийдвэр, хөрөнгийг устгасан байдлыг завсрын аудитаар үзэх

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 83,729.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 39,246.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 43,562.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 919.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга ирүүлээгүй, Санхүү байдлын тайланд өмнөх үеийн үр дүн 61.5 мянган төгрөгөөр зөрүүтэй татагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тайлант хугацаанд шинээр бүртгэсэн 14,185.0 мянган төгрөгийн Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, хэрэгслийг тавилга эд хогшил дансанд, 25,000.0 мянган төгрөгийн Хөгжлийн төлөвлөгөө /2020-2040 он/ -г бусад хангамжийн материал дансанд буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн

### 4.3 Албан шаардлага

Хөрөнгийн тооллогыг эд хөрөнгийн тооллогын бүртгэл НХМаягт БМ-8-д хуулж бичсэн боловч тооллогын комисс, эд хариуцагч гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Мал амьтад дансны 7,800.0 мянган төгрөгийн оны эхний үлдэгдэл хэвээр, тоолсон тооллогын бүртгэл байхгүй, бүртгэлд 52 толгой хуц байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.4-ийн 1/эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх; гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн "Хөрөнгө шийдвэрлэх тухай" 07 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн данснаас 28,718.6 мянган төгрөгийн, бараа материалын данснаас 7,044.2 мянган төгрөгийн, нийт 35,762.8 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассан. Уг тогтоолоор 4,727.0 мянган төгрөгийн өвсний үлдэгдэл хасагдсан ба Тамгын газрын ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон хөрөнгийг нягтлан шалгаж дахин үнэлгээ тогтоох боломжтой эсэхэд хяналт хийж, тайланг 2022 оны 1 дүгээр улиралд Хурлын хуралдаанд хэлэлцүүлэх үүрэг болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 35, хугацаандаа байршуулсан 110 мэдээлэл ба дараа жилийн төсвийн төсөл, өмнөх оны хэмнэлт, давсан урамшуулал, хандив тусламж, түүний зарцуулалт, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.2-т " мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" , Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 340.2 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй ба анхан шатны баримтад хүлээн авсан, өгсөн хүний гарын үсэг, шалгасан нягтлан бодогчийн гарын үсэг бүрэн зурагдаагүй, тамга тэмдэг дарж албажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг зааврын дагуу бүрэн хөтөлж, хэвших ба худалдан авалт хийх бүрд НӨАТ-ийн цахим төлбөрийн баримтыг бүрдүүлж байх

##### **2. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

Ковид цар тахлын хязгаарлалтын дэглэмийн үед шуурхай штабын үүрэг гүйцэтгэсэн албан хаагч нарт 3-р сард 579.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг 9 албан хаагчид олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг баталгаажуулаагүй олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-р хавсралт дах заалтыг болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-р хавсралтын дагуу нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр /

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	ЗДТГ	7	83,729.1	2	39,246.5			3	43,562.8	2	919.8